



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.18 № 330

танай _____ ны № _____ т

Г ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ Г
ДАРГА Б.ДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гурванбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гурванбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 775.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 809.2 сая төгрөг буюу 104.3 хувиар орлогыг бүрдүүлж, 33.3 сая төгрөгийн орлого илүү оруулсан нь өмнөх оны өр барагдуулалтыг нөхөж оруулсантай холбоотой байна.

Аймгаас 1,131.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, сумын орон нутгийн төсвөөс 1,881.4, ОНХС-гаас 302.1, үндсэн үйл ажиллагааны орлогоос 76.1, нэмэлт дансаар 299.5, урьд оны үлдэгдлээс 175.0 сая төгрөгийн буюу нийт 3,865.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 3,118.2 сая төгрөгийн зарцуулж, 747.7 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Аудитын гол асуудал

Гурванбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлага 71.8 сая төгрөгөөр буурч, өглөг 197.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яам жилийн эцэст зарим зардлын

санхүүжилтийг танасантай холбоотой байна.

Мөн үндсэн хөрөнгө 761.7 сая төгрөгөөр өсч, бараа материал 8.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Шилэн дансанд мэдээлэх 167 мэдээлэлээс 165 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	953,524.90	1,074,161.91
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,681,044.32	3,442,737.13
	Нийт хөрөнгийн дүн	3,634,569.22	4,516,899.04
	Нийт өр төлбөрийн дүн	-	197,291.24
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,634,569.22	4,319,607.80
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,634,569.22	4,516,899.04
Санхүү үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,897,184.76	5,349,710.29
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,038,326.53	4,664,671.71
	Үйл ажиллагааны үр дүн	858,858.23	685,038.58
	Үйл ажиллагааны бус үр дүн	8,918.00	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	849,940.23	685,038.58
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	556,651.92	556,651.92
	Тайлант оны үр дүн	849,940.23	685,038.58
	Эцсийн үлдэгдэл	2,784,628.99	4,319,607.80
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,241,152.04	4,675,120.50
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,507,625.37	4,179,290.72
	Үйл ажиллагааны ЦМГ	733,526.67	495,829.79
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(286,510.66)	(281,694.84)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(86,069.75)	(13,675.00)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	360,946.26	200,459.95
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	186,317.94	547,264.21
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	547,264.21	747,724.15
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,855,431.50	4,120,222.85
	Урсгал зардал	1,993,732.50	3,884,968.65
	Хөрөнгийн зардал	736,255.20	221,579.20
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	1,929,490.50	1,826,434.03
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	70,000.00	76,114.70

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурванбулаг сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутгийн онцлогт тохирсон уламжлалт мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, Хүн-Байгальд ээлтэй орчин, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, хүний хөгжлийг дээдэлнэ” гэж тодорхойлжээ.

Мөн Монгол Улсын хууль, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, эрдэм боловсролтой, тав тухтай амьдрах нөхцөл бүрдсэн, Хүний төлөө-Хөгжлийг дээдэлсэн зөв бодлого барьж ажиллан, тогтвортой эдийн засгийг бий болгох бодит мэдээ мэдээллээр хангах зорилго тавин ажиллажээ.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гурванбулаг сумын ТТЗ нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 775.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 809.2 сая төгрөг буюу 104.3 хувиар орлогыг бүрдүүлж, 33.3 сая төгрөгийн орлого илүү оруулсан нь өмнөх оны өр барагдуулалтыг нөхөж оруулсантай холбоотой байна.

Аймгаас 1,131.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, сумын орон нутгийн төсвөөс 1,881.4, ОНХС-гаас 302.1, үндсэн үйл ажиллагааны орлогоос 76.1, нэмэлт дансаар 299.5, урьд оны

үлдэгдлээс 175.0 сая төгрөгийн буюу нийт 3,865.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 3,118.2 сая төгрөгийн зарцуулж, 747.7 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Тав. Аудитын гол асуудал

Гурванбулаг сумын ТТЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлага 71.8 сая төгрөгөөр буурч, өглөг 197.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яам жилийн эцэст зарим зардлын санхүүжилтийг танасантай холбоотой байна.

Мөн үндсэн хөрөнгө 761.7 сая төгрөгөөр өсч, бараа материал 8.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансанд мэдээлэх 167 мэдээлэлээс 165 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өглөг, авлагыг нэмэгдүүлэхгүй ажиллахад анхаарах.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.8 сая төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс 0.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж өглөө.

5.1.1 Төлбөрийн акт

Тус сум нь Гамшгаас хамгаалах сангийн зардлаас 0.5 сая төгрөгийг шагнал урамшууллын зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.*” гэж заасныг тус тус үндэслэн гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2 Төлбөрийн акт

Тус сумын 2025 оны Газрын төлбөрийн орлогыг 0.3 сая төгрөгөөр төсөвт дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;*”, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д “*Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-т “*төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй.*” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2.1 Албан шаардлага

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЖДҮДС-гийн санхүүгийн тайланд "Багийн бичил бизнес"-ийн зээлийн 17519.1, "Цэнгэл сан"-гийн зээлийн 7,426.9 нийт 24,946.0 мянган төгрөгийн авлагатай, тус авлагын үлдэгдлийг барагдуулах, бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Сумын ЖДҮДС, ХХС-гийн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 12 сарын мэдээ, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 12 сарын мэдээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хягаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	2	2			2			

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл: Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт алдаа			Үүнээс	Зөвлөмж
--	------------	--	--	--------	---------

Алдааны товч утга			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ЗДТГ	2	127,530.1	2	127,530.1								
Сумын ИТХ	1	3,374.9	1	3,374.9								
Сумын ОНХС	1	11,120.8	1	11,120.8								
Дүн	4	142,025.8	4	142,025.8								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ИТХ	2	377.0	1	377.0								
Сумын ОНХС	1	19,500.0			1	19,500.0						
Сумын ЗДТГ	5	5,254.8	2	1,000.0	1	2,260.0	1	1,994.8	1	0		
Сумын ТТЗ	3	829.0	2	829.0			1	0				
Дүн	11	25,960.8	3	2,206.0	3	21,760.0	1	1,994.8	1	0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сумын ИТХ	1	0					1	0
Сумын ЗДТГ	1	0					1	0
Сумын ТТЗ	1	0					1	0
Дүн	3	0					3	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ЗДТГ	1	600.0	1	600.0				
Сумын ИТХ	1	110.0	1	110.0				
Дүн	2	710.0	2	710.0				
Нийт дүн	5	710.0	2	710.0			3	0